



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 01 өдөр Дугаар 31

Хэрлэн сум

XXXI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын цомхотгосон хурал 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 83,3 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврын өгөв.

ХЭЛЭЛЦСЭН нь:

1.Дэн буудлуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажил зохион байгуулсан талаарх мэдээлэл:

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэ,*

2.Улсын Онцгой комиссын 20 дугаар хуралдааны шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг 05 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах шийдвэр гаргасантай холбогдуулан аймгийн хэмжээнд тогтоосон хязгаарлалтыг сунгах эсэх талаар шийдвэрийн төсөл танилцуулах:

*Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа,*

3.Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас шийдвэрлүүлэхээр ирүүлсэн хүсэлтийг хэлэлцүүлэх:

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах*

4.Адуунчулуун ХК-наас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн албан бичгийг танилцуулах:

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Бат-Эрдэнэ,*

5.Петрочайна Дачин Тамсаг ХХК-аас хилийн Баянхошуу боомтоор газрын тосны тээвэрлэлт хийхэд тулгамдаж буй асуудлын тухай хэлэлцэх:

*Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа,*

6.Дорнод аймгийн нутаг дэвсгэрт сум дэлбэрч хүний амь нас эрсэдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай танилцуулах:

*Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,*

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Хэрлэн сумын Засаг даргын орлогч дарга, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.1.Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулдаг Сод, Билэг дэн буудлуудыг 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэхийг,

1.2.Хэрлэн суманд үйл ажиллагаагаа явуулдаг Амар, Баян дэн буудлуудад хяналт шалгалтын ажлын хэсгээс хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлсний дараа үйл ажиллагааг нээхийг,

1.3.Хэрлэн суманд үйл ажиллагаагаа явуулдаг Арвин, Тулга, Дорнын зэрэглээ буудлуудын үйл ажиллагааг хаах эсэх асуудлыг Мэргэжлийн хяналтын газар шалгаж шийдвэрлэхийг,

Хэрлэн сумын Засаг даргын орлогч дарга, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

1.4.Хэрлэн суманд дэн буудлын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад Шинэ төрлийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйтгэл хийх, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байлгах тухай баталгааны гэрээ байгуулж ажиллахыг,

Гурав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.1.Эрүүл мэндийн газраас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу иргэдэд эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлдэг автомашины засвар үйлчилгээний зардалд 3,500,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Эрүүл мэндийн газарт олгохыг,

3.2.Цагдаагийн газраас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн хүсэлтийн дагуу Хэрлэн сумын 6 дугаар багийн нутаг орон сууцны 24 дүгээр байрны орчимд иргэдийн бөөгнөрөл үүсгэж байгаа цэгүүдийг хянах зорилгоор 2 цэгт байршуулах 2 теле камер худалдан авахад зардалд 1,840,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас аймгийн Цагдаагийн газарт олгохыг,

3.3.Хэрлэн сумын 6 дугаар багийн нутаг орон сууцны 3 дугаар байшингийн дээвэр дээр аянга бууж дээвэр хуурсан эсэхийг шалгаж аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Дөрөв.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

4.1. Адуунчулуун ХК-наас аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох хууль, журмын дагуу гомдлыг шийдвэрлэхийг,

Тав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д. Мөнхтуяа-д:

5.1. Петрочайна Дачин Тамсаг ХХК-д хилийн Баянхошуу боомтоор газрын тосны тээвэрлэлт хийхдээ өдөрт 24-өөс дээш автомашин боомтоор зорчуулахгүй тухай албан бичиг хүргүүлэхийг,

Зургаа. АЗДТГ-ын Цэргийн штабын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа О. Ганзориг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т. Ганзориг,

Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа Б. Бямбаа,

Зэвсэгт хүчний 0327 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Т. Тогмидүүмий нарт:

6.1. Дорнод аймгийн нутаг дэвсгэрт хуучин ОХУ-ын цэргийн анги, байгууллагууд байрлаж байсан газруудад тэсэрч, дэлбэрэх бодис илрүүлэх, аюулгүй болгох хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, холбогдох зардлыг аймгийн Засаг даргын нөөцөөс шийдвэрлэхийг,

6.2. Зэвсэгт хүчний жанжин штабын даргад дээрх ажлыг зохион байгуулах зөвшөөрөл хүсэх тухай албан бичиг хүргүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



М. БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА

Д. БАТТУЛГА